



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

### Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дүрэм батлах тухай” 116/565 дугаар тушаал, Газрын дүрмийн 4.1.2, 4.1.16, 4.1.29, 7.1.1, 7.1.19 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь::

1. “Сайн туршлага-2024” арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шалгуур үзүүлэлтийг гуравдугаар, шаардагдах төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. “Сайн туршлага 2024” арга хэмжээг нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган, холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, сурталчилж, дэлгэрүүлж ажиллахыг /Ажлын хэсэг/-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 17,989,000 /арван долоон сая есөн зуун наян есөн мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Р.Дулмаа/, Ахлах нягтлан бодогч /Л.Насанбуян/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс /У.Бат-Очир /-т үүрэг болгосугай.


ДАРГА



П. ЭРХЭМБУЛГАН

1550001429

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн  
1/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## “САЙН ТУРШЛАГА 2024” АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### **Зорилго:**

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээнд тэргүүн туршлага нэвтрүүлэх, бүтээлч, оновчтой санал, санаачлагыг дэмжих замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

### **Хийгдэх үйл ажиллагаа**

1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагын дунд “Сайн туршлага-2024” арга хэмжээг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 2024 онд шинээр нэвтрүүлсэн шилдэг сайн туршлага, шинэ бүтээл, оновчтой санал, санаачилга бүхий бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлах, туршлагаа хуваалцах, шилдэг технологийг шалгаруулж, урамшуулна.

2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахад дэвшил гарган шилдгээр шалгарсан болон гэрчилгээ авсан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг 2025 оны 6 дугаар сар хүртэл зохион байгуулна.

3. Тусламж, үйлчилгээний 6 чиглэлд шилдгээр шалгарсан 12 бүтээл, шилдгээр шалгарсан 20 болон нийтийн хүртээл болохуйц сайн туршлага танилцуулгыг эмхэтгэн “Сайн туршлага-2024” товхимолд хэвлүүлж, цахим санд байршуулна. Мөн Нийслэлийн өдрийн арга хэмжээний үзэсгэлэнд оролцуулна.

### **Хамрах хүрээ:**

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллага, тусгай мэргэжлийн төв

### **Зохион байгуулагч байгууллага:**

Нийслэлийн Эрүүл мэндийн газар  
Эрүүл мэндийн чанарын холбоо

### **Хугацаа:**

1. “Сайн туршлага 2024” арга хэмжээний анхан шатны шалгаруулалтыг харьяа эрүүл мэндийн байгууллагын тасаг нэгж, дүүргийн эрүүл мэндийн төв өрхийн эрүүл мэндийн төвийн дунд 2024 оны 10 дугаар сарын 18-ны дотор зохион байгуулна.
2. Анхан шатнаас шалгаран ирсэн бүтээлийг 2024 оны 10 дугаар сарын 21 нд Нийслэлийн Эрүүл мэндийн газар хүлээн авч, эцсийн шатны шалгаруулалтыг 2024 оны 10 дугаар сарын 22-аас 23-ны өдрүүдэд зохион байгуулна.
3. “Сайн туршлага 2024” оролцсон бүтээлийн үзэсгэлэн, шагнал гардуулах үйл ажиллагаа 10 дугаар сарын 26-ны өдөр хийнэ.

4. Шилдгээр шалгарсан болон гэрчилгээ авсан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 2 дугаар улирлыг дуустал цахимаар болон газар дээр нь очиж судална

**“Сайн туршлага-2024” арга хэмжээнд оролцох бүтээлийн чиглэл:**

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах асуудлыг шийдвэрлэн ажилласан бүтээл,
2. Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологи, хэрэгжилтийн үр дүн
3. Шинээр нэвтрүүлсэн оношилгооны технологи, хэрэгжилтийн үр дүн
4. Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн шинэ технологи, арга аргачлал
5. Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологи, хэрэгжилтийн үр дүн
6. Өөрсдийн бүтээлч санаачилгаар хийсэн оюуны шилдэг бүтээлүүд /боловсруулсан ном товхимол, удирдамж, гарын авлага, төсөл, хөтөлбөр/

**Шалгаруулах журам:**

1. “Сайн туршлага 2024” арга хэмжээнд 2023 оны 10 дугаар сараас хойш эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр хийсэн технологи, арга аргачлал, санал санаачилга хамаарна.
2. Харьяа эрүүл мэндийн байгууллага анхан шатны шалгаруулалтаас тусламж, үйлчилгээний 6 чиглэл бүрээс шалгарсан шилдэг 2-3 бүтээлийн танилцуулга үр дүнгийн талаарх мэдээллийг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ирүүлнэ.
3. Сайн туршлага арга хэмжээнд ирүүлэх бүтээлд тавигдах шаардлага:
  - Сайн туршлагын нэр
  - Хэрэгжүүлсэн эмнэлэг, тасаг, нэгж, албан тушаалтан
  - Сайн туршлагын танилцуулга /бүтээл, арга, аргачлалын тайлбар, хэрэгжүүлсэн хугацаа, хамрах хүрээ, үр дүн, зарцуулсан төсөв, зураг/
4. 2-р шатны шалгаруулалтад ирүүлсэн материалтай ажлын хэсэг танилцаж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагын дунд зохион байгуулах бүтээлийн жагсаалтыг гаргана.
5. Харьяа эрүүл мэндийн байгууллага “Сайн туршлага-2024” сонгогдсон бүтээлийг үйл ажиллагаа зохион байгуулах танхимд байршуулна.
6. Үзэсгэлэнд оролцох материалыг биетээр, слайд, зурган болон видео /авчрах боломжгүй бол/ хэлбэрээр авчирна.
7. Ажлын хэсэг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж бүтээлийн чиглэл тус бүрээс эхний 2 байрыг шалгаруулна.

**Шагнал урамшуулал:**


1. “Сайн туршлага-2024” арга хэмжээнд ирүүлсэн бүтээлийн чиглэл бүрээс эхний 2 байр шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.
2. Сайн туршлагаар шалгарсан бүтээлийг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах сайн туршлага”-ын санд бүртгэн “Гэрчилгээ” олгоно.
3. “Сайн туршлага-2024” арга хэмжээнд оролцсон бүтээл бүрт “Батламж” олгоно.

4. “Сайн туршлага 2024” арга хэмжээний хоёрдугаар шатанд шалгарсан бүтээлийн үзэсгэлэн болон шагнал гардуулах үйл ажиллагаа 2024 оны 10 дугаар сарын 26 ны өдөр 10.00-14.30 цагт зохион байгуулна.
5. Шалгарсан бүтээл болон эхний 20-д шалгарсан болон нийтийн хүртээл болохуйц сайн туршлагыг “Сайн туршлага-2024” товхимолд оруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулна.

**Үр дүн:**

Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ бүтээл, оновчтой санал, санаачилга, ололт амжилтыг дэмжих, бусдад түгээн дэлгэрүүлснээр тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
1/156 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“САЙН ТУРШЛАГА 2024” АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч

Б.Батцоож Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга


Гишүүд:

Э. Энхжаргал	Лавлагаа шатны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн
Ц.Сонгиносүрэн	Статистик мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн
Д.Оюун-Эрдэнэ	Сувилахуй, хөнгөвчлөхийн тусламж, үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
Н.Мөнхжаргал	Анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
Д.Гэрэлцэцэг.	Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Т. Асрагчмаа	Мэдээллийн технологи, цахим эрүүл мэнд, хариуцсан мэргэжилтэн

**“САЙН ТУРШЛАГА 2024” АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГСДЫН  
БҮТЭЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Э.Энхжаргал	Лавлагаа шатны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн
Ц.Сонгиносүрэн	Статистик мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн
Д.Энхтүвшин	Харьяа байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
Г.Ганчимэг	Эрүүл мэндийн чанарын холбооны тэргүүн /зөвшилцсөнөөр/
Т.Алимаа	Эрүүл мэндийн чанарын холбооны төлөөлөл/зөвшилцсөнөөр

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн  
1/155 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**“САЙН ТУРШЛАГА 2024” АРГА ХЭМЖЭЭНД  
ИРҮҮЛСЭН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Үйл ажиллагаа	Авбал зохих оноо
1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах асуудлыг шийдвэрлэн ажилласан байдал.		
1	Нэвтрүүлсэн аргачлал, өртөг тодорхой байх	5
2	Нэвтрүүлсэн технологийн үр дүн	5
3	Нэвтрүүлсэн үйл ажиллагаа хэрэгжихүйц, шинэлэг	5
2. Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологи хэрэгжилтийн үр дүн		
1	Эмчилгээний технологийн аргачлал	5
2	Хэрэгжилтийн үр дүн, харьцуулалт,	5
3	Хэрэгжихүйц бодитой, шинэлэг байдал	5
3. Шинээр нэвтрүүлсэн оношилгооны технологи		
1	Оношилгооны технологийн аргачлал	5
2	Хэрэгжилтийн үр дүн, харьцуулалт,	5
3	Хэрэгжихүйц бодитой, шинэлэг байдал	5
4. Шинээр нэвтрүүлсэн сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн технологи		
1	Нэвтрүүлсэн аргачлал, өртөг тодорхой байх	5
2	Нэвтрүүлсэн технологийн үр дүн	5
3	Нэвтрүүлсэн үйл ажиллагаа хэрэгжихүйц, шинэлэг	5
5. Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологи		
1	Үйлчилгээний технологи аргачлал, өртөг тодорхой байх	5
2	Нэвтрүүлсэн технологийн үр дүн	5
3	Нэвтрүүлсэн үйл ажиллагаа хэрэгжихүйц, шинэлэг	5
6. Өөрсдийн бүтээлч санаачилгаар хийсэн оюуны шилдэг бүтээлүүд /боловсруулсан ном товхимол, удирдамж, гарын авлага, төсөл, хөтөлбөр/		
1	Шинээр боловсруулсан ном, товхимол, гарын авлага төсөл, хөтөлбөр	5
2	Үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн байдал	5
3	Үр дүн хэрэгжихүйц шинэлэг байдал	5